


**“ХАЙ БИ ОЙЛ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН БА ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**2020 оны 12 дугаар сарын 31**


<b>АГУУЛГА</b>	<b>Хуудас</b>
Удирдлагын хариуцлагын мэдэгдэл.....	3
Байгууллагын талаарх мэдээлэл.....	4
Хараат бус аудиторын тайлан.....	5-6
<b>САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b>	
Санхүүгийн байдлын тайлан.....	7
Дэлгэрэнгүй орлогын тайлан.....	8
Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан.....	10
Санхүүгийн тайлангийн тодруулгууд.....	11-28

**“ХАЙ БИ ОЙЛ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ**

Хай Би Ойл ХК-ийн (цаашид “Компани” гэх) ТУЗ-ийн дарга Баярсайхан овогтой Пүрэвбаатар, Гүйцэтгэх захирал Шарав овогтой Амар-Отгон, Ерөнхий нягтлан бодогч Базарсад овогтой Бадамханд, бид энэхүү тайлангийн 1-ээс ... дугаар хуудсанд толилуулсан тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

  
\_\_\_\_\_  
**Б.ПУРЭВБААТАР**  
ТУЗ-ийн дарга



  
\_\_\_\_\_  
**Б.БАДАМХАНД**  
Ерөнхий нягтлан бодогч

Монгол Улс, Улаанбаатар хот  
Огноо: 2021. оны 02 дугаар сарын 10

## **“ХАЙ БИ ОЙЛ” ХУВЬЦААТ КОМПАНИ**

Байгууллагын талаарх мэдээлэл

### **Үүсгэн байгуулах шийдвэр**

“Хай Би Ойл” ХК нь 2007 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын №41 тоот тогтоолын дагуу хувьцаат компанийн хэлбэрээр дахин зохион байгууллагдсан.

### **Үндсэн үйл ажиллагаа**

Техникийн хаягдал тосыг үйлдвэрийн аргаар боловсруулан мазут үйлдвэрлэх, худалдах

### **Гэрчилгээ**

“Хай Би Ойл” ХК нь 2007 оны 12 сарын 27-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж 2615134 тоот регистрийн дугаар бүхий, Улсын бүртгэлийн 9010001063 тоот гэрчилгээг авсан.

### **Хувь нийлүүлэгчид**

Нью Альфа ХХК	33%
Кибер циркл ХХК	32%
Би Ди Сек ҮЦК	16%
Монгол алтан минт ХХК	8%
GFSel ect Equity Fund	3%
Su Yu-Ping	1%
Бусад жижиг хувьцаа эзэмшигчид	6%
Хай Би Ойл ХК (халаасны хувьцаа)	2%
	100%

### **Төлөөлөн удирдах зөвлөл**

Б.Пүрэвбаатар	ТУЗ-ийн дарга
Р.Оюунбат	ТУЗ-ийн хараат гишүүн
С.Одгэрэл	ТУЗ-ийн хараат гишүүн
Ц.Батбаяр	ТУЗ-ийн хараат гишүүн
Б.Лхагвадорж	ТУЗ-ийн хараат гишүүн
А.Батбаяр	ТУЗ-ийн хараат гишүүн
Т.Тамир	ТУЗ-ийн хараат бус гишүүн
А.Харцага	ТУЗ-ийн хараат бус гишүүн

### **Гүйцэтгэх удирдлага**

Ш.Амар-Отгон	Гүйцэтгэх захирал
Б.Бадамханд	Ерөнхий нягтлан бодогч

### **Байнгын хаяг**

**“Хай Би Ойл” ХК**  
Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо,  
Сонсголонгийн /18135/-110

### **Аудитор**

**“Гэрэлт Хөхийн Тэнцвэр Аудит” ХХК**  
Монгол Улс, Улаанбаатар хот  
Баянгол дүүрэг, 2-р хороо  
МҮЭСТО, 217 тоот

## **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

### **Хай Би Ойл ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

#### **Дүгнэлт**

Бид Хай Би Ойл ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, Компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайллангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын ёс зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “МНБЁЗ-н дүрэм” гэх)-ийн дагуу компаниас хараат бус ба МНБЁЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

#### **Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг**

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай залыт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнзлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайллагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

#### **Санхүүгийн Тайллангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг**

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай залыт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй.

Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцаангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хувалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоо явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Гарын үсэг зурсан:



2021 оны 03 дугаар сарын 29-ний өдөр  
Монгол Улс, Улаанбаатар хот

ХАЙ БИ ОЙЛ ХК  
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тодруулгын дугаар	2020 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>Хөрөнгө</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5	35,692	252,040
Худалдааны болон бусад авлага	6	2,474,495	1,961,333
Бараа материал	7	126,223	134,311
Урьдчилж телсэн зардал/тооцоо	8	4,857	20,610
		<b>2,641,266</b>	<b>2,368,294</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	9	1,222,668	1,042,596
Биет бус хөрөнгө	10	869,917	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	11	-	1,691,234
		<b>2,092,585</b>	<b>2,733,829</b>
<b>Нийт хөрөнгө</b>			
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Худалдааны болон бусад өглөг	12	136,545	481,761
		<b>136,545</b>	<b>481,761</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Хойшлогдсон татварын өглөг	13	-	78,004
		-	<b>78,004</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>			
<b>Эздийн өмч</b>			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	14	5,211,895	5,211,895
Халаасны хувьцаа	14	(54,281)	-
Нэмж төлөгдсөн капитал	14	4,592,503	4,592,503
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		1,108,461	-
Хуримтлагдсан ашиг алдагдал	15	(6,261,272)	(5,262,040)
<b>Эздийн өмчийн дүн</b>			
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>			
		<b>4,597,306</b>	<b>4,542,358</b>
		<b>4,733,851</b>	<b>5,102,123</b>

ХАЙ БИ ОЙЛ ХК  
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

<b>Мянган төгрөгөөр</b>	<b>Тодруулгын дугаар</b>	<b>2020 оны 12-р сарын 31</b>	<b>2019 оны 12-р сарын 31</b>
1 Борлуулалтын орлого (цэвэр)	18	416,358	760,367
2 Борлуулсан барааны өртөг	19	276,104	415,669
3 Нийт ашиг (алдагдал)		140,253	344,697
3 Хүүний болон бусад орлого	20	505,179	2,488
5 Ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал	21	174,019	268,956
6 Бусад олз ба гарз	21	(1,679,026)	64,836
9 Татварын өмнөх ашиг (алдагдал)		(1,207,612)	143,065
10 Орлогын татварын зардал	17	-	14,598
12 Татварын дараах ашиг (алдагдал)		(1,207,612)	128,467
12 Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал		(1,207,612)	128,467
14 Орлогын нийт дүн		(1,207,612)	128,467
13 Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	16	(23.62)	2.46

ХАЙ БИ ОЙЛ ХК  
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

<b>Мянган төгрөгөөр</b>	<b>Өмч</b>	<b>Халаасны хувьцаа</b>	<b>Нэмжк төлөгдсөн капитал</b>	<b>Хэрэngийн дахин үнэлгээний нэмэгдэл</b>	<b>Хуимтлагдсан ашиг</b>	<b>Нийт дүн</b>
<b>2018 оны 12-р сарын 31</b>	<b>5,211,895</b>	-	<b>4,592,503</b>	-	<b>(5,390,507)</b>	<b>4,413,891</b>
Залруулсан үлдэгдэл	5,211,895	-	4,592,503	-	(5,390,507)	4,413,891
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	-	128,467	128,467
<b>2019 оны 12-р сарын 31</b>	<b>5,211,895</b>	-	<b>4,592,503</b>	-	<b>(5,262,040)</b>	<b>4,542,358</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	208,380.55	208,380.55
Залруулсан үлдэгдэл	5,211,895	-	4,592,503	-	(5,053,660)	4,750,739
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	-	(1,207,612)	(1,207,612)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	1,108,461	-	1,108,461
Өмчид гарсан өөрчлөлт	-	(54,281)	-	-	-	(54,281)
<b>2020 оны 12-р сарын 31</b>	<b>5,211,895</b>	<b>(54,281)</b>	<b>4,592,503</b>	<b>1,108,461</b>	<b>(6,261,272)</b>	<b>4,597,306</b>

ХАЙ БИ ОЙЛ ХК  
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

<b>Мянган төгрөгөөр</b>	<b>2020 оны 12-р сарын 31</b>	<b>2019 оны 12-р сарын 31</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	462,108	913,262
Бараа борлуулсан, үйчилгээ үзүүлсний орлого	459,686	913,262
Бусад мөнгөн орлого	2,422	-
Мөнгөн зарлагын дүн (-)	645,833	715,265
Ажиллагчдад олгосон мөнгө	143,643	132,931
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	14,237	38,861
Бараа материал худалдан авахад төлсөн	174,829	294,143
Ашиглалтын зардал төлсөн	17,347	22,278
Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	16,208	25,274
Татварын байгууллагад төлсөн	56,695	78,546
Даатгалын төлбөрт төлсөн	241	289
Бусад мөнгөн зарлага	222,633	122,944
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(183,725)</b>	<b>197,997</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	373	2,089
Хүлээн авсан хүүний орлого	373	2,089
Мөнгөн зарлагын дүн (-)	33,000	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	33,000	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(32,627)</b>	<b>2,089</b>
Валютын ханшны зөрүү	4	8
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(216,348)</b>	<b>200,094</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>252,040</b>	<b>51,945</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>35,692</b>	<b>252,040</b>